



## ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГЫН ТӨСВИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

Газрын дарга: С.Энхзаяа  
Утас: 261663  
Цахим хуудас:  
enkhzaya@audit.gov.mn

Аудитын менежер: Л.Одгэрэл  
Утас: 260512  
Цахим хуудас: odgerell@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Болормаа  
Цахим хуудас: bolorb@audit.gov.mn  
Шинжээч О.Дашжамц

Монгол Улсын Үндэсний Аудитын  
Газар  
Улаанбаатар-46  
Бага тойруу 6  
Засгийн газрын IY байр  
Цахим хуудас: www.audit.gov.mn

#### АГУУЛГА

---

Оршил  
Санхүүгийн дотоод хяналт  
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хавсралт 3: Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн  
тайлан

## **Оршил**

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн багцын 2013 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна. Менежментийн захидалд санхүүгийн зарим үйл ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын тайланд аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, объект дээрх үе шат, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитаар Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2013 оны нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ болон цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан, тодруулгыг баталгаажуулан, санал дүгнэлт гаргалаа.

### **Санхүүгийн дотоод хяналт**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Аудитын явцад Үндсэн хуулийн цэцийн санхүүгийн дотоод хяналтыг үнэлэхэд үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөн ажилласан байна.

Ийнхүү уг бодлогын баримт бичгийг бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгосноор санхүүгийн дотоод хяналтын иж бүрэн тогтолцоо бий болох юм.

### **Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд**

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2013 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг нэгтгэн хөндөгдсөн дараах гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

## **Төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар**

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд их засварын ажилд батлагдсан хөрөнгийг 9.5 сая төгрөгөөр хэтрүүлж өр үүсгэсэн, гадаад томилолтын зардлыг төлөвлөсөн хэмжээнээс 9.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн, зарим гадаад томилолтын зардлын анхан шатны баримт дутуу байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, мөн “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад материалыг шаардан гаргуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шатахууны зардлыг 9.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Засгийн газрын 2007 оны “Суудлын автомашины талаар авах арга хэмжээний тухай” 349 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 4.5-т “...заасан лимитээс үндэслэлгүйгээр давсан тохиолдолд тухайн автомашиныг ашигласан албан тушаалтан болон жолоочоор хэтэрсэн зардлыг нөхөн төлүүлэх...” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын даргын албан тушаалын хэрэгцээнд ашиглахаар “Монгол Хьюндай Автоматив” ХХК-аас Соната маркийн автомашиныг худалдан авсан боловч жолоочийн орон тоо батлагдаагүйгээс автомашины ашиглалтад тавих хяналт тодорхой эзэнгүй байна.

## **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2012 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2 зөвлөмж өгснийг 100 хувь биелүүлж ажилласан байна.

## **Аудитын санал дүгнэлт**

Бид Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2013 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, МУ-ын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эдгээр стандартад зааснаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор касс, харилцахын болон бусад анхан шатны баримтыг дэлгэрэнгүй, хураангуй бүртгэл, тайлангийн зохих үзүүлэлттэй тулган шалгав.

Бидний дүгнэлтээр Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь бүгд материаллаг зүйлсийн хувьд Монгол Улсад мөрдөж байгаа стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөвөөр илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Ерөнхий аудитор санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-86

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА  
Ж.АМАРСАНАА ТАНАА

2014.04.25 № 678

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудчитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үндсэн хуулийн цэцийн удирдлага нь Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлэгдсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



*(Handwritten signature)*  
А.ЗАНГАД



# ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГЫН ТӨСВИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Менежментийн захидал

### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1 Зардал

Асуудал 2 Шатахуун

Асуудал 3 Үндсэн хөрөнгө

## **Менежментийн захидал**

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг хэрхэн сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан юм.

Энэ нь Үндсэн хуулийн цэцийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргаж өгсөн бөгөөд таны зүгээс зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх талаар анхаарал тавина гэдэгт найдаж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Үндсэн хуулийн цэцийн санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

**ҮАГ-ын ажиглалт**

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд их засварын ажилд батлагдсан хөрөнгийг 9.5 сая төгрөгөөр хэтрүүлж өр үүсгэсэн, гадаад томилолтын зардлыг төлөвлөсөн хэмжээнээс 9.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн, зарим гадаад томилолтын зардлын анхан шатны баримт дутуу байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т заасныг зөрчсөн байна.

**Эрсдэлүүд**

Төсвийн хөрөнгийг хэтрүүлэн зарцуулах, санхүүгийн сахилга бат алдагдах

**Зөвлөмж**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, мөн “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 19.1.3-т “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад материалыг шаардан гаргуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 7 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна. Цаашид хэрэгжүүлж ажиллах болно.

**ҮАГ-ын ажиглалт**

Шатахууны зардлыг 9.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Засгийн газрын 2007 оны “Суудлын автомашины талаар авах арга хэмжээний тухай” 349 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 4.5-т “...заасан лимитээс үндэслэлгүйгээр давсан тохиолдолд тухайн автомашиныг ашигласан албан тушаалтан болон жолоочоор хэтэрсэн зардлыг нөхөн төлүүлэх...” гэсэн заалтыг мөрдөөгүй байна.

**Эрсдэлүүд**

Шатахуун, сэлбэг хэрэгслийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт суларч, үргүй зардал гаргах, хөрөнгө мөнгө ашиглах, шамшигдуулах

**Зөвлөмж**

Суудлын автомашины гүйлтийн лимитийг холбогдох журмын дагуу тогтоож, мөрдөх, шатахууны тогтоосон лимитийн дагуу зарцуулалтын тооцоог тооцож цаг тухай бүрт хийж, хэтрүүлсэн шатахууны үнийг тухайн автомашиныг ашигласан албан тушаалтан болон жолоочоор хэрэглэгчээр нөхөн төлүүлж байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 7 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна. Цаашид хэрэгжүүлж ажиллах болно.



**ҮАГ-ын ажиглалт**

Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын даргын албан тушаалын хэрэгцээнд ашиглахаар “Монгол Хьюндай Автоматив” ХХК-аас Соната маркийн автомашиныг худалдан авсан боловч жолоочийн орон тоо батлагдаагүйгээс автомашины ашиглалтад тавих хяналт тодорхой эзэнгүй байна.

**Эрсдэлүүд**

Үндсэн хөрөнгийн бүртгэл, тэдгээрийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт суларч, үргүй зардал гаргах, хөрөнгө мөнгө ашиглах, шамшигдуулах.

**Зөвлөмж**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу автомашины асуудлыг Төрийн өмчийн хороонд танилцуулж, холбогдох шийдвэрийг гаргуулах.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 7 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна. Цаашид хэрэгжүүлж ажиллах болно.

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант үе: 2013/01/01 - 2013/12/31		/төгрөгөөр/	
ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>1,936,558.00</b>	<b>44,452.00</b>	
Кассанд байгаа бэлэн мөнгө	1,936,558.00	44,452.00	
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>10,171,161.80</b>	<b>6,611,247.80</b>	
Хангамжийн материал	10,171,161.80	6,611,247.80	
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,107,719.80</b>	<b>6,655,699.80</b>	
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>	<b>-</b>	<b>-</b>	
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,827,764,391.04</b>	<b>1,979,064,230.06</b>	
Биет хөрөнгө	1,825,564,391.12	1,977,414,230.16	
Барилга, байгууламж	1,703,805,565.00	1,803,805,565.00	
Хуримтлагдсан элэгдэл	(20,527,777.92)	(30,870,171.78)	
Авто тээврийн хэрэгсэл	-	49,600,000.00	
Хуримтлагдсан элэгдэл	-	(826,666.66)	
Машин, тоног төхөөрөмж	115,622,904.00	127,704,960.00	
Хуримтлагдсан элэгдэл	(69,204,029.04)	(74,718,288.60)	
Тавилга, аж ахуйн эд хогшил	171,956,082.20	177,207,282.20	
Хуримтлагдсан элэгдэл	(99,541,553.12)	(100,849,599.00)	
Түүх соёлын дурсгалт зүйлс	11,160,000.00	11,160,000.00	
Номын фонд	12,293,200.00	15,201,149.00	
Биет бус хөрөнгө	2,199,999.92	1,649,999.90	
Програм хангамж	7,810,000.00	7,810,000.00	
Хасагдуулга	(5,610,000.08)	(6,160,000.10)	
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,827,764,391.04</b>	<b>1,979,064,230.06</b>	
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,839,872,110.84</b>	<b>1,985,719,929.86</b>	
Богино хугацаат өр төлбөр	0.01	288,073.28	
Өглөг	0.01	288,073.28	
Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	288,073.27	
Бусад өглөг	0.01	0.01	
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>0.01</b>	<b>288,073.28</b>	
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>0.01</b>	<b>288,073.28</b>	
Засгийн газрын оруулсан капитал	2,015,457,867.72	2,015,457,867.72	
Хуримтлагдсан үр дүн	(182,141,718.07)	(36,581,972.32)	
Өмнөх үеийн үр дүн	(182,141,718.07)	(182,141,718.07)	
Тайлант үеийн үр дүн	-	145,559,745.75	
Дахин үнэлгээний зөрүү	6,555,961.18	6,555,961.18	
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,839,872,110.83</b>	<b>1,985,431,856.58</b>	
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,839,872,110.84</b>	<b>1,985,719,929.86</b>	

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2013/01/01 - 2013/12/31		/төгрөгөөр/
ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	-	-
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	-	-
Улсын төсвөөс	549,447,500.00	753,883,500.00
Урсгал	501,622,600.00	584,683,000.00
Хөрөнгийн	47,824,900.00	169,200,500.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	-	448,820.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	448,820.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	549,447,500.00	<b>754,332,320.00</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	-	-
<b>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</b>	313,808,503.74	<b>402,430,898.00</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	283,589,589.84	364,198,161.00
Цалин	283,589,589.84	364,198,161.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	30,218,913.90	38,232,737.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	30,218,913.90	32,022,165.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	30,218,913.90	25,042,804.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	1,916,863.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	3,512,384.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	1,550,114.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	6,210,572.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	140,080,520.37	118,261,971.03
Тогтмол зардал	14,656,222.00	10,490,747.92
Гэрэл цахилгааны зардал	4,147,753.00	4,080,390.00
Түлш, халаалтын зардал	6,472,395.00	6,122,778.00
Цэвэр, бохир усны зардал	4,036,074.00	287,579.92
Бусад бараа үйлчилгээний зардал	125,424,298.37	107,771,223.11
Бичиг хэргийн материал	7,820,820.70	8,224,264.00
Тээвэр, шатахууны зардал	31,498,698.00	28,931,070.00
Шуудан холбооны зардал	9,520,297.51	11,614,340.83
Дотоод томилолтын зардал	4,596,580.00	1,700,000.00
Гадаад томилолтын зардал	13,064,184.00	23,058,658.30
Ном, хэвлэлийн зардал	473,300.00	921,360.00
Төрийн албан хаагчийн мэргэшил дээшлүүлэх зардал	3,564,000.00	1,278,600.00
Сургалт семинарын зардал	-	310,500.00

Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	125,000.00	120,000.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	1,485,904.35	7,523,764.00
Урсгал засварын зардал	5,201,803.00	1,584,246.00
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	71,955.00	585,000.00
Гадаадын зочны зардал	1,983,527.00	1,020,810.00
Элэгдлийн зардал	43,258,228.81	20,808,609.98
Газрын төлбөр	2,640,000.00	-
Хог хаягдал устгах, цэвэрлэх	120,000.00	90,000.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	119,001,264.21	9,051,968.22
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	41,417,088.00	-
Улсын төсвөөс ой тэмдэглэхэд олгох	41,417,088.00	-
Төсвийн хуваарилагдаагүй зардал	77,584,176.21	9,051,968.22
Төвлөрүүлэх шилжүүлэг	77,584,176.21	9,051,968.22
<b>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</b>	<b>38,956,000.00</b>	<b>79,027,737.00</b>
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	38,956,000.00	79,027,737.00
Мөнгөн хэлбэрээр	38,956,000.00	2,947,237.00
Нэг удаагийн тэтгэмж	38,956,000.00	2,947,237.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	76,080,500.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>611,846,288.32</b>	<b>608,772,574.25</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>(62,398,788.32)</b>	<b>145,559,745.75</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>(62,398,788.32)</b>	<b>145,559,745.75</b>

## АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант үе: 2013/01/01 - 2013/12/31		/төгрөгөөр/
ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ДҮН	ТАЙЛАНТ ОНЫ ДҮН
Тусламж, санхүүжилтын орлого	549,447,500.00	753,883,500.00
Улсын төсвөөс	549,447,500.00	753,883,500.00
Урсгал	501,622,600.00	584,683,000.00
Хөрөнгийн	47,824,900.00	169,200,500.00
Бараа, үйлчилгээний орлого	1,894,746.00	448,820.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	1,894,746.00	448,820.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1,894,746.00	448,820.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>551,342,246.00</b>	<b>754,332,320.00</b>
Ажиллагчидтай холбогдсон зардал	313,808,503.73	402,162,824.73
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	283,589,589.83	364,078,597.33
Цалин	271,396,914.83	359,183,597.33
Бусад нэмэгдлүүд	12,192,675.00	4,895,000.00
Унаа, хоолны хөнгөлөлт	12,192,675.00	4,895,000.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	30,218,913.00	38,084,227.40
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	30,218,913.00	31,159,822.40
Тэтгэврийн даатгалын шимтгэл	-	24,235,417.45
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	2,769,761.99
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	3,462,202.48
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	692,440.48
Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	6,924,405.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	178,336,434.86	94,332,107.05
Тогтмол зардал	14,656,222.00	10,490,747.92
Гэрэл цахилгааны зардал	4,147,753.00	4,080,390.00
Түлш, халаалтын зардал	6,472,395.00	6,122,778.00
Цэвэр, бохир усны зардал	4,036,074.00	287,579.92
Бусад бараа үйлчилгээний зардал	124,724,212.86	83,841,359.13
Бичиг хэргийн зардал	7,067,130.00	4,664,350.00
Тээвэр, шатахууны зардал	31,498,698.00	28,931,070.00
Шуудан, холбооны зардал	9,520,297.51	11,614,340.83
Дотоод томилолтын зардал	4,596,580.00	1,700,000.00
Гадаад томилолтын зардал	14,958,930.00	23,058,658.30
Ном, хэвлэлийн зардал	473,300.00	1,360,020.00
Төрийн албан хаагчийн мэрэгшил дээшүүлэх зардал	3,564,000.00	1,278,600.00

Сургалт семинарын зардал	-	310,500.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	125,000.00	120,000.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	1,485,904.35	7,523,764.00
Урсгал засварын зардал	5,201,803.00	1,584,246.00
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	71,955.00	585,000.00
Гадаадын зочны зардал	1,983,527.00	1,020,810.00
Газрын төлбөр	2,640,000.00	-
Хог хаягдал устгах, цэвэрлэх	120,000.00	90,000.00
ТАТААС	77,584,176.21	9,051,968.22
Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдэд	77,584,176.21	9,051,968.22
Бусад татаас, шилжүүлэг	77,584,176.21	9,051,968.22
Төвлөрүүлэх шилжүүлэг	77,584,176.21	9,051,968.22
<b>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ</b>	<b>38,956,000.00</b>	<b>79,007,737.00</b>
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	13,335,400.00	2,927,237.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,620,600.00	76,080,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	569,729,114.80	584,554,637.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(18,386,868.80)	169,777,683.00
Хөрөнгийн орлого	-	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	54,382,799.00	171,669,789.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>54,382,799.00</b>	<b>171,669,789.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(54,382,799.00)</b>	<b>(171,669,789.00)</b>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(72,769,667.80)</b>	<b>(1,892,106.00)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	74,706,225.80	1,936,558.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,936,558.00	44,452.00

## АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2013/01/01 - 2013/12/31				/төгрөгөөр/
ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2012 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл</b>	<b>1,833,937,199.72</b>	<b>6,555,961.18</b>	<b>(119,742,929.75)</b>	<b>1,720,750,231.15</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	187,012,665.00	-	-	187,012,665.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	39,980,003.00	-	-	39,980,003.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	(45,472,000.00)	-	-	(45,472,000.00)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(62,398,788.32)	(62,398,788.32)
	-	-	-	-
<b>2012 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>2,015,457,867.72</b>	<b>6,555,961.18</b>	<b>(182,141,718.07)</b>	<b>1,839,872,110.83</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,015,457,867.72	6,555,961.18	(182,141,718.07)	1,839,872,110.83
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	145,559,745.75	145,559,745.75
<b>2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>2,015,457,867.72</b>	<b>6,555,961.18</b>	<b>(36,581,972.32)</b>	<b>1,985,431,856.58</b>

## АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2013/01/01 - 2013/12/31				/төгрөгөөр/
ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>768,759,600.00</b>	<b>747,172,457.78</b>	<b>21,587,142.22</b>	<b>97.19</b>
<b>II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>768,759,600.00</b>	<b>747,172,457.78</b>	<b>21,587,142.22</b>	<b>97.19</b>
<b>IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>598,359,600.00</b>	<b>577,971,957.78</b>	<b>20,387,642.22</b>	<b>96.59</b>
Бараа, үйлчилгээний зардал	518,943,700.00	498,964,220.78	19,979,479.22	96.15
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	364,078,600.00	364,078,597.33	2.67	100.00
Үндсэн цалин	345,346,000.00	359,183,597.33	(13,837,597.33)	104.01
Унаа хоолны хөнгөлөлт	18,732,600.00	4,895,000.00	13,837,600.00	26.13
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,377,900.00	38,084,227.40	293,672.60	99.23
Тэтгэврийн даатгал	24,262,400.00	24,235,417.45	26,982.55	99.89
Тэтгэмжийн даатгал	2,822,600.00	2,769,761.99	52,838.01	98.13
ҮОМШӨ ний даатгал	3,528,900.00	3,462,202.48	66,697.52	98.11
Ажилгүйдлийн даатгал	706,200.00	692,440.48	13,759.52	98.05
Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	7,057,800.00	6,924,405.00	133,395.00	98.11
Бараа, үйлчилгээний бусад зардал	116,487,200.00	96,801,396.05	19,685,803.95	83.10
Бичиг хэрэг	4,320,600.00	4,664,350.00	(343,750.00)	107.96
Гэрэл цахилгаан	4,297,900.00	4,080,390.00	217,510.00	94.94
Түлш, халаалт	13,026,900.00	6,122,778.00	6,904,122.00	47.00
Тээвэр (шатахуун)	37,686,327.00	28,931,070.00	8,755,257.00	76.77
Шуудан холбоо	11,774,900.00	11,614,340.83	160,559.17	98.64
Цэвэр, бохир ус	3,561,600.00	287,579.92	3,274,020.08	8.07
Дотоод албан томилолт	2,285,000.00	1,700,000.00	585,000.00	74.40
Гадаад томилолт арга хэмжээ	13,789,473.00	23,058,658.30	(9,269,185.30)	167.22
Ном хэвлэл авах	4,716,000.00	3,829,309.00	886,691.00	81.20
Нормын хувцас зөөлөн эдлэл	120,000.00	120,000.00	-	100.00
Урсгал засвар	1,250,000.00	1,584,246.00	(334,246.00)	126.74
Төлбөр хураамж болон бусад зардал	6,540,000.00	7,523,764.00	(983,764.00)	115.04
Гадаад зочны зардал	7,738,500.00	1,020,810.00	6,717,690.00	13.19
Хог хаягдал устгах цэвэрлэх	120,000.00	90,000.00	30,000.00	75.00
Биеин тамирын уралдаан тэмцээн	500,000.00	585,000.00	(85,000.00)	117.00
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	2,120,000.00	1,589,100.00	530,900.00	74.96
Сургалт хурал зөвлөгөөний зардал	2,120,000.00	1,589,100.00	530,900.00	74.96
Газрын төлбөр	2,640,000.00	-	2,640,000.00	-



Татаас ба урсгал шилжүүлэг	79,415,900.00	79,007,737.00	408,163.00	99.49
Өрх гэрт олгох шилжүүлэг	79,415,900.00	79,007,737.00	408,163.00	99.49
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	3,335,400.00	2,927,237.00	408,163.00	87.76
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	76,080,500.00	76,080,500.00	-	100.00
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>170,400,000.00</b>	<b>169,200,500.00</b>	<b>1,199,500.00</b>	<b>99.30</b>
1. Дотоод хөрөнгө оруулалт	170,400,000.00	169,200,500.00	1,199,500.00	99.30
Төсвийн хөрөнгөөр санхүүжсэн хөрөнгө оруулалтын дүн	170,400,000.00	169,200,500.00	1,199,500.00	99.30
төсвийн хөрөнгөөр санхүүжих тоног төхөөрөмж	70,400,000.00	69,200,500.00	1,199,500.00	98.30
Төсөвт газрын их засвар	100,000,000.00	100,000,000.00	-	100.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>768,759,600.00</b>	<b>752,617,982.78</b>	<b>16,141,617.22</b>	<b>97.90</b>
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	448,820.00	(448,820.00)	-
Төсвөөс санхүүжих	768,759,600.00	752,169,162.78	16,590,437.22	97.84
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,936,558.00	(1,936,558.00)	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	44,452.00	(44,452.00)	-
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>АЖИЛЛАГСАД БҮГД</b>	<b>30.00</b>	<b>30.00</b>		
Удирдах ажилтан	10.00	10.00		
Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00		
Үйлчлэх ажилтан	10.00	10.00		
СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/				